



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/128

Эрдэнэт

Зардал батлах, хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 а, 29.2, 33 дугаар зүйлийн 33.1.6, Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 02 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн төрийн албан хаагчдын 2017 оны сургалтын төлөвлөгөөний дагуу 2017 оны 3 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулагдах "Хүний хөгжил-Төрийн алба" сэдэвт сургалт, семинарын зардлыг хавсралтаар баталсугай.

2.Сургалтын зардал 15710500 /Арван таван сая долоон зуун арван мянга таван зуун/ төгрөгийг 2017 оны Засаг даргын нөөц сан, хуваарилагдаагүй бусад зардлын жагсаалтад тусгагдсан Төрийн албан хаагчдын мэдлэг, чадвар бий болгох хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын
17-ны өдрийн 1128 дугаар захирамжийн хавсралт

"ХҮНИЙ ХӨГЖИЛ-ТӨРИЙН АЛБА" СЭДЭВТ СУРГАЛТ СЕМИНАРЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Зардлын нэр	Тоо	Нэг бүрийн зардал	Нийт зардал
1	Сургалт зохион байгуулах багш нарын цагийн хөлс	7	250000	1750000
2	Сургалт, семинарт урилгаар оролцож буй хүмүүсийн зочид буудал, өглөө, өдөр, оройны хоол, замын зардал	10	175000	1750000
3	Заалны түрээс	7	275000	1925000
4	Анонс	2	500000	1000000
5	Цайны цагийн завсарлага 2 удаа	900	4120	3708000
6	Дэвтэр	500	6500	3250000
7	Бал	450	450	202500
8	Бал	50	10000	500000
9	Хавтас	500	1000	500000
10	Мандат	500	2150	1075000
11	Хөтлөгч	1	50000	50000
	БҮГД			15710500